

.Асгат сумын ЗДТГ-ын 2021 оны 1 сарын

Үйл ажиллагааны тайлан

2021 оны 01 сарын 27-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Коронавирус халдвар /Ковид-19/-ын тархалтаас урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээллийг өдөр бүр иргэдэд сурталчилж, ажиглалтыг байрыг СТ-д шилжүүлж шаардлагатай зүйлүүдийг бэлдсэн.Сумын засаг дарга, ИТХ-ын нарын ажлын хэсэг хөдөөгийн багт ажиллаж байна.

Сумын ОК-оос УБ хотоос иргэдээ татан авч гэрийн ажиглалтанд 6 иргэнийг ажиглаж байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Байгаль орчин:

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Эрүүл мэндийн чиглэлээр:

2021.01.14-2021.01.15ний өдрүүдэд Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналт, Онцгой байдлын газрын 3 байгууллагын хамтарсан шалгалт ирж зөвлөн туслах шалгалт хийлээ. Шалгалтаар Коронавирусын халдварын бэлтгэл бэлэн байдал, Улсын онцгой комисс, Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын Сумын онцгой комисс, Засаг даргын тамгын газар, сумын Эрүүл мэндийн төвийн сайдын албан даалгавар, тушаалын хэрэгжилт, тусгаарлан эмчлэх байр, тусгаарлан ажиглах байрны тохижилт, ковидын хамгаалах хувцас хэрэгсэл, эм тариа, ариутгалын бодисын нөөц, хүн хүчний бэлтгэл бэлэн байдлыг шалгахад Тусгаарлан эмчлэх байр болон Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа хангалттай сайн гэж үнэлэгдсэн бол ковидын хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодисын нөөцнөө хангалтгүй 8 хоногийн нөөц байгааг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үүрэг өгсөн. Мөн одоогийн Тусгаарлан ажиглах байр нь стандартын шаардлага хангаагүй тул шинэ соёлын төвийн байранд тусгаарлан ажиглах байрыг стандартын дагуу бэлдэхийг үүрэг болгосон.

Боловсролын чиглэлээр:

2021 оны 2 дугаар сарын 01 –ний өдрөөс цахимаар хичээллэхтэй холбогдуулан сурагчдын судалгаа болон өвөлжилтийн мэдээ, отроор өвөлжиж буй алслагдсан бүс нутагт амьдарч байгаа сурагчдын маршрутыг гаргаж байгууллагын хэмжээнд нэгтгэн цахимаар хичээллэх бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Байгууллагын хүрээнд анги танхим өрөө тасалгааг жавелионы уусмалаар цэвэрлэж 7 хоног бүрийн лхагва, баасан гаригуудад нэгдсэн их цэвэрлэгээ хийн ажиллаж байна

Дотуур байрны сурагчдын ариун цэврийн байгууламжийн ажил 80%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Цэцэрлэг: Хөл хориотой үед ажил үүргээ хэвийн ажиллуулж байна. Байгуулагын багш ажилчид бүгд өдөр бүр ажлын байрандаа үүрэгт ажлуудыг хийж байна. Зам талбайн цас , хог хаягдал нүүрсний хог зэргийг зөөж орчноо цэвэрлэж дууссан.

Бүлгийн багш нар бүлгийн хүүхдүүдтэй ангийн дотоод группээр байнга эцэг эхтэй холбоотой байж заавар зөвлөгөө өгч ажилладаг мөн гэрийн даалгавар гарын авлага бэлдэн олшруулж хэвлэн тараасан.

Ковид -19 халдвараас урьдчилан сэргийлэн Байгуулагын QRкодыг байршуулан багш ажилчид болон байгуулагат нэвтэрсэн бүх ард иргэдэд танилцуулан кодоо уншуулах зааврын дагуу уншуулан ажиллаж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдуулж. Хуралдаанаар доорх асуудалыг хэлэлцсэн.

Байнгын асаргааны ахмад настны сунгалт 1, ахмадын тухай хуулинд тусгагдсаны дагуу тэжээн тэтгэх үр хүүхэдгүй ганц бие ахмад настанд түлээ нүүрсний хөнгөлөлт үзүүлэх материалыг тус тус хэлэлцэн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжин холбогдох материалыг ХХҮГазрын Халамжийн тэтгэвэр тэтгэмж хариуцсан мэргэжилтэн Н.Адъяасүрэнд хүргүүллээ.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 6 малчин, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 1 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
НЗЭЗБХМэргэжилтэн

З.Ядамжав